

ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2022 оны 12 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 6 дугаар хурал 11-р сарын 23-ны өдөр, Зөвлөлийн 7 дугаар хурал 11-р сарын 28-ны өдөр тус тус хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн VI Хуралдаанаар:-

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 6 дугаар хурлаар 8 асуудал хэлэлцсэнээс:

1. Газрын нэгдмэл сангийн ангилал хооронд шилжүүлэх тухай
2. Сэргэлэн-Зуунмод сумын хилийн цэсийн тухай
3. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хаягдлыг булшлах зардлын нэгж тариф шинэчлэх тухай асуудлуудыг хэлэлцээд материалын бүрдэл хангалтгүй гэж үзэн аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит бус 4-р Хурлаар дахин хэлэлцэхээр шийдвэрлэн хуралд өргөн мэдүүлэгдэж байгаа асуудлуудын бичиг баримтын бүрдлийг хангаж мэдүүлэх талаар аймгийн Засаг даргад албан бичгээр уламжлав.

4. 2023 онд ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарь батлах тухай

5. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай

6. Богдхан төмөр замын чигийн дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал уламжлах тухай асуудлуудыг хэлэлцэж Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

7. Шинэ суурьшлын бүсийн 3 дахь ээлжийн орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

8. Аймгийн ИТХ-ын 2022 оны тайлангийн тухай асуудлыг хэлэлцээд Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороонд шилжүүлэв.

9. Хурлын Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 13 дугаар Хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Даваа" гарагийн 09 цагт хуралдуулж, 13 асуудал хэлэлцүүлэхээр тогтов.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн VII Хуралдаанаар:-

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 7 дугаар Хурлаар 8 асуудал хэлэлцлээ. Үүнд:-

1. Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн аймгийн 2023 оны төсвийн төслийн тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

2. Орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын дүнг нэгтгэн батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

3. Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

4. Сэргэлэн-Зуунмод сумын хилийн цэсийн тухай

5. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хаягдлыг булшлах зардлын нэгж тариф шинэчлэн батлах тухай 2 асуудлыг төсөл өргөн мэдүүлэгчид буцаан аймгийн ИТХ-ын Зөвлөлийн дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулав.

6. Газрын нэгдмэл сангийн ангилал хооронд шилжүүлэх тухай асуудлыг дахин хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

7. Сумдын багийн нэр, дугаар тогтоох санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 13 дугаар хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж тусган аймгийн ИТХ-ын даргын захирамжаар албажуулахаар чиглэл өгөв.

8. Төв Эрдэнэс ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны тухай мэдээллийг хэлэлцээд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо, Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороодод шилжүүлэв.

Аймгийн ИТХ-ын 13 дугаар Хуралдааны тов тогтсонтой холбогдуулан Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороо, Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин,

хөдөөгийн хөгжлийн хороод 11-р сарын 30-ны өдрөөс эхлэн ажиллаж хороодын хурлаа зарлаад байна.

Аймгийн ИТХ-ын 13 дугаар Хуралдааны тов тогтсонтой холбогдуулан Ажлын алба бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойд зориулсан Хүндэтгэлийн Хуралдааныг зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жил, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ой энэ жил тохиож байна. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж “Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутгийн удирдлагыг хэрэгжүүлнэ” гэж хуульчилсан. Тэр цаг үеэс Хурлын шинэ үеийн түүх эхэлж, өдгөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хөгжлийнхөө 30 жилийнхээ босгон дээр ирсэн бөгөөд энэхүү түүхт ойн хүндэтгэлийн хуралдааныг Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал XVII жарны “Буян үйлдэгч” хэмээх усан бар жилийн өвлийн эхэн сарын шинийн 3-ны харагчин хонь өдөр буюу арванхоёрдугаар сарын 26-ны зохион байгууллаа.

Хүндэтгэлийн Хуралдааныг Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн нээж Монгол Улс Ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлж ирсэн өнгөрсөн 30 жилд Төв аймгийн иргэдийнхээ эрхэм дээд шийдвэр, эрх чөлөөт сонголтоор нийт 7 удаагийн бүрэн эрхийн хугацааг ардаа үзэж, 8 удаагийн хуралд давхардсан тоогоор 352 Төлөөлөгчид сонгогдож аймаг, орон нутгийнхаа хөгжлийн төлөө өөр өөрийн түүхэн хувь нэмрээ оруулж, тогтоол шийдвэрүүдийг батлан боловсруулж ирснийг бахархан тэмдэглээд, зочид төлөөлөгчдөд баяр хүргэлээ.

Хүндэтгэлийн хуралдаанд УИХ-ын гишүүд, 8 бүрэн эрхийн хугацааны Төв аймгийн ИТХ-ын дарга, Аймгийн Засаг даргаар ажиллаж байсан үе үеийн удирдлагууд, үе үеийн ИТХ-ын төлөөлөгчид, Хурлын ажлын албанд ажиллаж байсан ахмад ажилтнууд оролцлоо.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жил, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн Хүндэтгэлийн Хуралдааны үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны долдугаар сарын 11-ний өдрийн “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дүгээр зарлигийн дагуу Төв аймгийн ЗДТГ-ын хуралдааны их танхимын хойморт Эзэн Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах ёслолыг зохион байгууллаа.

Эзэн Чингис хааны эш хөрөгт аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нар хүндэтгэл үзүүллээ.

Хүндэтгэлийн хуралдаанд Онцгой байдлын Ерөнхий Газрын харъяа Үндэсний аврах бригадын хөгжмийн салбарын үлээвэр найрал хөгжмийн салааны бүрэлдэхүүн оролцож ёслолын үйл ажиллагаанд “Төрийн дуулал”, “Төв аймгийн сүлд дуу”-г эгшиглүүлэн хүндэтгэл үзүүллээ.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жил, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн Хүндэтгэлийн Хуралдаанд аймгийн ИТХ-ын шагналаар шагнагдсан эрхэм хүмүүст шагнал гардуулах үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

Төв аймгийн ИТХ-ын 2022 оны 10-р сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Төв аймгийн Баян-Өнжүүл сумын уугуул, Зуунмод сумын харъяат Улсын Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалд “Хүндэт иргэн” цол олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шагналыг Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээний үеэр гардуулан өгсөн.

Түүний аймгийнхаа хөгжилд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн “Хүндэт иргэн” цол хүртээж, энгэрийн тэмдэг, хүндэтгэл, мөнгөн шагналаар шагналаа.

Мөн аймгийн ИТХ-ын “Үндэсний соён гэгээрүүлэгч, шашин соёлын нэрт зүтгэлтэн, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч II богд лувсандамбийдонмэ”-н нэрэмжит шагналаар Төв аймгийн Сэргэлэн сумын уугуул Цэдэвийн Мэндсайханд олгохоор аймгийн ИТХ-ын 2022 оны 10-р сарын 10-ны өдрийн 09 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн бөгөөд нутгийн удирдлагын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 30 жилийн ойн хүндэтгэлийн хуралдааны үеэр гардуулан өглөө.

Мөн Нутгийн өөрөө удирдах байгууллага, төлөөллийн байгууллагад аймаг, орон нутгийнхаа иргэдийн итгэлийг хүлээн нийт 8 удаагийн сонгуульд төлөөлөгчөөр сонгогдон иргэдийнхээ дуу хоолой, хүсэл зоригийг төлөөлж, эрх ашгийг нь илэрхийлэн хамгаалж, бататган хангахын төлөө үзэл бодол, мэдлэг оюунаа зориулж аймаг орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт бүтээн байгуулалт ирээдүй хойчийнхоо сайн сайхны төлөө залуу нас хөдөлмөр бүтээлээ зориулсан аймгийн ИТХ-ын анхны дарга Занаажавын Гончигсүрэн, 1992 оны Архуст

сумын аймгийн ИТХ-ын төлөөлөгч Бат-Очирын Балбар, 1992 оны Баянжаргалан сумын аймгийн ИТХ-ын төлөөлөгч Баатарын Ойдов болон үеийн аймгийн ИТХ-ын төлөөлөгч Навааншаравын Чулуунжав, Раднаагийн Батмөнх, Баяртын Цэнд-Очир, Цогзолноровын Нанзаддорж, Сундуйн Батболд, Д.Баярбат, Хинаатын Цэрэнлхам, Агвансамдангийн Оюунчимэг нарыг,

Мөн аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 1992 оны Алтанбулаг сумын аймгийн ИТХ-ын төлөөлөгч Лувсанцэрэнгийн Хад, Жадамбын Ханджав, Аюушжавын Бат-Очир, Дамдинсүрэнгийн Сэрээтэр, Цэрэндагвын Гүенбаатар, Нанзадын Отгондалай нарыг шагналаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жил, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойн Хүндэтгэлийн Хуралдааны бэлтгэл ажлыг бүрэн хангаж 1992-2024 оны 8 бүрэн эрхийн төлөөлөгчдийн зургаар 8 монтажийг хийлгэн Хуралдааны танхимд байршуулснаас гадна Нутгийн удирдлага сонинг бэлтгэн хэвлүүлэн төлөөлөгчдөд хүргүүлэн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд:-

Төв аймгийн ИТХ гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын бие даасан Чөжү хот, Бүгд найрамдах социалист Вьетнам улсын Хоа бинь муж, БНХАУ-ын Гуанду мужтай найрамдалт харилцаа тогтоон ажиллаж байгаа бөгөөд 2020-2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төрийн залгамж чанарыг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Дэлхий нийтэд корона вируст цар тахал гарч, үүнээс шалтгаалан бидний гадаад хамтын ажиллагаа тодорхой хэмжээнд удаашрах, хамтарсан уулзалт зөвлөгөөн хийх, харилцан айлчлах зэрэг ажлууд хийгдэлгүй 3 жил гаруй болсон байна.

Төв аймгийн ИТХ, БНСВУ-ын Хоа Бинь мужийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан “Санамж бичгийн хүрээнд” БНСВУ-ын Хоа Бинь мужийн ИТХ-ын дарга Бүй Дик Хинь таны урилгаар Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Жамбалсүрэн тэргүүтэй тус аймгийн төлөөлөгчид энэ сарын 10-15-ны өдрүүдэд БНСВУ-ын Хоа Бинь мужид ажиллаж, мужийн Ардын зөвлөл, Намын хороо, Ардын хорооны удирдлагатай уулзан орон нутгийн хамтын ажиллагааны талаар санал солилцож, ирэх жилүүдэд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов.

Бусад үйл ажиллагааны хүрээнд:

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 24 албан бичиг хүлээн авснаас хариутай албан бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. Аймгийн ИТХ-ын даргаас 39 бичиг гаргаж, аймгийн ИТХ-д 5 өргөдөл бүртгэгдснээс 4 өргөдөл шийдвэрлэгдэж 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Монгол Улсад нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сумдын ИТХ-ууд тус ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Баянжаргалан сумын ИТХ 11-р сарын 11-ний өдөр, Баянхангай сумын ИТХ 11-р сарын 30-ны өдөр, Архуст сумын ИТХ 2022 оны 11-р сарын 25-ны өдөр нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 13 дугаар хуралдааны тов тогтсонтой холбогдуулан Ажлын албанаас Төсвийн талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, төсвийн ил тод байдлыг сайжруулах, төсөв, санхүүгийн талаар ойлгомжтой мэдээллийг ард иргэдэд өгөх зорилгоор анх удаа төсвийн төслөө иргэд олон нийтэд нээлттэй танилцуулж, төсөвт тусгах иргэдийн санал хүсэлтийг авч, эрдэмтэд, мэргэжлийн байгууллагууд, ажил олгогчидтойгоо хамтарсан олон нийтийн хэлэлцүүлгийг Аймгийн ИТХ-ын “Төсөв, санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо”-ноос санаачлан 11-р сарын 25-ны Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд өдөр зохион байгууллаа.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:

Төв аймгийн болон сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Хамтарсан баг”-ийн гишүүдийг чадавхжуулах зүүн бүсийн сургалтыг Баяндэлгэр суманд 2022-11-03-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Төв аймгийн Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ, Архуст, Баянжаргалан, Баян сумдын нийт нийт 56 албан хаагчийг хамрууллаа.

1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” хамтарсан багийн үндэсний V чуулганд оролцлоо

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” хамтарсан багийн үндэсний V чуулганд Жаргалант, Лүн, Заамар, Зуунмод, Алтанбулаг, Эрдэнэсант, Баянчандмань, Баян сумдын Засаг дарга, хамтарсан баг хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан.

2.Төв ТВ-тэй хамтран тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбарын агентлаг байгууллагын удирдлага холбогдох албан хаагчдын дунд аймгийн “Шүгэл хэлэлцүүлэг” бэлтгэн цувралаар олон нийтэд түгээж байна.

3.ЕБС, цэцэрлэгийн орчинд анхааруулах тэмдэглэгээ байршуулах, хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1,7 сая төгрөгийн санхүүжилтээр 2 сургууль, 2 цэцэрлэгийн эрсдэл өндөртэй 4 байршилд анхааруулах салбар, тусгаарлах тюмб байршуулах ажлыг зохион байгуулсан.

4.Хүүхдийг үл хайхрах нь Хүүхдийн ирээдүйд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс хүүхдийг үл хайхрахгүй байхыг уриалж байна. ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ, тээврийн хэрэгслээ хөдөлгөхөөсөө өмнө “Шалга-нягтал” зэрэг 4 төрлийн шторк, 7 төрлийн постер бэлтгэн олон нийтэд түгээсэн.

5.Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зөвлөгөөнийг анх удаа зохион байгуулж Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны мал бүхий иргэд, Аргалант, Баянцогт, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант сумдын ИТХ-ын дарга нар, хэсгийн төлөөлөгч, малчдын төлөөллийг хамруулан зохион байгууллаа.

6.Дэлхий нийтээр зам тээврийн ослын улмаас амь нас нь хохирсон иргэдийг дурсах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хичээх өдөр” нэртэйгээр 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж аймгийн цагдаагийн газар, онцгой байдлын газар, төв АЗЗА, аймгийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газраас цуваа үүсгэн анхааруулах самбар байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.

7.“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймгийн бүсчилсэн зөвлөгөөнийг Дархан-Уул аймагт 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн ГХУСАЗСЗ, цагдаагийн газар, төрийн бус байгууллагын нийт 26 албан хаагч хамрагдлаа.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 11 сарын 07-ны өдөр танхимаар зохион байгуулж, тэмдэглэлээр 12 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов. Нэгдсэн шуурхайд өгөгдсөн үүргийг цахим үнэлгээний систем болох tov.unelgee.gov.mn-д оруулж, тайлагнаж байна.

11-р сард Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж, 9 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын 2022.12.04-ний хуралдаанд хэлэлцүүлэх 8 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барьсан.

Улс тунхагласны баяраар Аймгийн ИТХ-ын ахмад ажилтан М.Эрдэнэдалайг “Алтан хуудас”-нд мөнхжүүлэх, мөн төрийн албан хаагчдыг аймгийн шагналаар шагнах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 78 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Төв аймгийн Нийтийн номын сангийн албан хаагчид болон Төв аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Хишигдолгор нар 2022 оны 10 сарын 31- нээс 11-р сарын 4-ны өдрүүдэд БНСУ-ын Пёнтек хотын захиргаа болон Бээдари номын сангийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.


Хүний нөөцийн асуудалтай холбогдолтой 8 тушаал, 2 захирамж, мөнгөн тусламж үзүүлэх 4 захирамж, хүндэтгэл үзүүлэх 1 захирамж гаргасан. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системд албан хаагчдын мэдээллийг оруулж баяжилт хийсэн.

Удирдлагын академийн богино хугацааны чиглүүлэх сургалт, анх төрийн албанд орж буй албан хаагчдын чадавхижуулах сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээллийг нэгтгэж, Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд хүргүүлсэн. Албан хаагчдад Монгол бичгийн 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.1. Салбар зөвлөлийн 7 дугаар хуралдааныг 2022.11.14-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж 2 асуудлыг хэлэлцлээ. Хуралдаанд оролцвол зохих 10 гишүүнээс 7 нь оролцов.



1. 18 байгууллагаас ирүүлсэн 38 албан хаагчаар төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх саналыг хэлэлцээд төрийн албаны хууль тогтоомжийн шаардлага хангасан 35 албан хаагчийг тангараг өргүүлэхээр шийдвэрлэв.

2. Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн 3 албан хаагчийн саналыг хэлэлцэн танхимын хуралдаанаар дахин хэлэлцэхээр хойшлууллаа.

1.2. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан Төрийн албаны зөвлөлийн 47 дугаар хуралдаанаар "Чадахуйн зарчмын хэрэгжилт" сэдвээр Төв аймгийн 24 байгууллагад хийсэн хүний нөөцийн аудитын тайланг хэлэлцлээ. Аудитын дүгнэлттэй уялдуулан гаргасан шийдвэр, зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, явц, үр дүнг тайлагнан ажиллахыг аудитад хамрагдсан байгууллагуудын удирдлага, эрх бүхий албан тушаалтан, салбар зөвлөлд даалгалаа.




1.3. Үндсэн хуульт Бүгд Найрамдах Улс тунхагласны түүхт 98 жилийн ойг тохиолдуулан аймаг, сумын хэмжээнд 35 албан хаагч "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг" өргөлөө. 2022 онд нийт 103 албан хаагч "Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая" хэмээн тангараг өргөжээ.

Энэ удаагийн тангараг өргөх ёслолын ажиллагааны

үеэр төр, захиргааны болон нутгийн удирдлагын ахмад зүтгэлтэн Маналжавын Эрдэнэдалай нь Төв аймгийн "Алтан дэвтэр"-ын 6 дахь "Алтан хуудас"-т өөрийн ажил, амьдралын аврин туршлагыг дурсган үлдээж, үе үеийн төлөөлөл болсон албан хаагчдад сургамж, сургаалиа захилаа. Мөн салбарын хэмжээнд үр бүтээлтэй ажиллаж байгаа 13 албан хаагчийг төрийн болон салбарын, аймгийн шагналуудаар шагнаж урамшууллаа.



1.4. Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 97 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 96.70%-ийн биелэлттэй байна.



1.5. Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Ирсэн бичиг албан	251	202	180	22	89.10%
2	Ирсэн өргөдөл, гомдол	16		16	0	100%
3	Явсан бичиг албан	169	150	142	8	94.66%

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2.1. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн дэмжлэг үзүүлэх цахим сургалт 30 удаа зохион байгуулагдаж, салбар зөвлөлийн гишүүд, холбогдох сум, агентлаг, байгууллагын албан хаагчид хамрагдсан.



2.2. Албан хаагчдын харилцааны ур чадварыг сайжруулах, эерэг хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор Үйлчилгээний нэгдсэн төв, ШШГГ-аас ирүүлсэн захиалгын дагуу “ТАны ёс зүй-харилцаа” сэдэвт сургалтыг Төв аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Мөнхгэрэл хийж, цаг үеийн зарим мэдээллийг өглөө. Сургалтад төр, төрийн бус байгууллагын 58 ажилтан, албан хаагч хамрагдсан юм.




2.3. Ур чадварт суурилсан хүний нөөцийн удирдлагын чиглэлээр Дорнод, Дундговь, Сүхбаатар, Төв аймагт хэрэгжиж буй үйл ажиллагааны хүрээнд харилцан сайн туршлага солилцох цахим уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Энэхүү ээлжит уулзалтаар Дорнод аймгийн 24 агентлаг, 14 сумын албан хаагчдын дунд “Хүний нөөцийн гол ур чадвар хөгжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас танилцуулж, туршлага солилцов.



3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

3.1. Тайлант хугацаанд төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөх тусгай шалгалт 1 удаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тоо нөхөх сонгон шалгаруулалт 1 удаа тус тус зохион байгуулагдсан. Ингэснээр 2022 онд тусгай шалгалтыг 6 удаа, сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгууллаа.

Сул орон тооны нөхөн хангалтыг 2022 оны 11 дүгээр 28-ны байдлаар танилцуулбал: (тусгай шалгалт, шилжин томилгоо)



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 11 дүгээр сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **15** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **5580** иргэнд, өдөрт дунджаар **250-300** иргэнд хүргэн үйлчилсэн байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Цахим мэдээлэл солилцооны нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 11 сард аймгийн хэмжээнд **708** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **511** лавлагаа үйлчилгээ авчээ.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **5** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан, одоогийн байдлаар шийдвэрлэх хугацаа болоогүй 5 гомдол байна.

Байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **200** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **80** иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

Мөн аймгийн энэ сард манай төвд Эрүүл мэндийн салбарын нээлттэй өдөрлөг, болон аймгийн ИТХ-аас зохион явуулсан ТӨСӨВ-2023 ард иргэдээс санал авах нээлттэй хэлэлцүүлэг тус тус болж өнгөрлөө.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Сумдын засаг дарга нарт Онцгой байдлын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн Засаг даргын 2022 оны 01 албан даалгаврын хэрэгжилт ирүүлэх тухай ” 33/235 албан бичиг гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/649 дүгээр захирамжаар “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги”-ийг шинэчлэн байгуулсан.

Улсын чанартай авто замын зорчих хэсгийн дагуу цасан шуурганы улмаас үүссэн нөхцөл байдал ажилласан талаар материалыг Баянчандмань, Төв, Налайх АЗЗА ТӨХК-уудаас татан авч гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 03/02, 03/03, 03/04, 03/05 дугаар тодорхойлолтыг Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Аймгийн 27 сумын Засаг дарга нарт сумын шуурхай штаб, ой, хээрийн түймэр, объектын гал түймэр, эрэн хайх, аврах ажиллагаа, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд сумын Засаг даргын Тамгын газрын нөөцөд байвал зохих багаж хэрэгслийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн.

Алба хаагчдыг гал түймэр, гамшиг ослын голомтод болон дасгал сургуулийн үед үүрэг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг ханган, тактикийн алдаа дутагдал гаргуулахгүй байх зорилгоор “Гал түймэр унтраах дүрэм”, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”, “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ээр давтан сургалт явуулж шүүлэг авсан.

Онцгой байдлын газрын алслагдсан Батсүмбэр сум дахь Гал түймэр унтраах, аврах анги, интернэтийн 4G хүлээн авагч модемыг байршуулан интернэтийн асуудлыг Юнител ХХК-тай байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэсэн Холбооны хэрэгслийн бэлэн байдал цэнэглэлт сүлжээ, гаралт оролтын хэвийн байдлыг ханган 28 техник хэрэгсэлийг хэвийн ажилгааг хянаж бэлэн байдалд оруулан ажиллаж байна. Мөн сансарын хөдөлгөөнт холбооны гар утасны цэнэглэлт хяналт тавин ажиллаж байна.

Сумдын засаг дарга нарт Онцгой байдлын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн Засаг даргын 2022 оны 01 албан даалгаврын хэрэгжилт ирүүлэх тухай ” 33/235 албан тоот хүргүүлэн хэрэгжилтийг нэгтгэсэн.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Цээл суманд зохион байгуулан Жаргалант, Угтаалцайдам, Сүмбэр, Заамар сумдын удирдах бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгуулсан.

Төв аймгийн Дэлгэрхаан, Заамар сумдад отроор яваа Өвөрхангай аймгийн Сант сумын малчин Г.Хорлоо, Б.Содномдаржаа, Ж.Долгормаа, Ч.Батбаатар нар Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд гомдол гаргасны дагуу Дэлгэрхаан, Заамар сумдын Засаг дарга болон бусад холбогдох албан тушаалтантай холбогдож заавар, чиглэл өгч ажилласан.

Заамар суманд отроор яваа Өвөрхангай аймгийн Өлзийт сумын малчин Г.Хорлоо болон сумын малчдын дунд үүссэн маргааныг сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/202 дугаартай захирамж “Отор нүүдэлд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай”-аар ажлын хэсэг гаргаж газар дээр нь очиж малчдад заавар, зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна.

Дэлгэрхаан суманд отроор яваа Өвөрхангай аймгийн Сант сумын малчин Ч.Батбаатар, Б.Содномдаржаа, Ж.Долгормаа нартай холбогдож авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллээ өгч, аймгийн Засаг даргын албан даалгаврыг цахимаар хүргүүлэн ажилласан.

Аймгийн хэмжээнд баригдах 9 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 450,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Барилга байгууламж шинээр ашиглалтад оруулах байнгын ашиглалтад авах улсын комисст 2 удаа ажилласан.

Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 12 аж ахуйн нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгосон.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд тухайн сумдад зохион байгуулагдах ангиллын сургалтын удирдамж, хуваарийг батлуулсан.

Удирдамжид тусгагдсан хуваарийн дагуу сумдын мэргэжлийн анги, Онцгой комиссын гишүүд, хил залгаа сумдын удирдах бүрэлдэхүүн нийт 219 ажилтан, алба хаагчдад танхимын сургалтыг зохион байгууллаа. Цээл сумын ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн нийт 142 сурагчдад газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах арга хэмжээ, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан бол сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нийт 29 хүүхдэд “Гал бол аюул” сэдэвт танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд сумын техник хэрэгсэлийн бэлэн байдал, мэргэжлийн ангийн алба хаагчдын хувийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг хийж дутуу болон бэлтгэл бэлэн байдлаа дутуу хангасан алба хаагчдад сануулга өгч ажиллав.

Цээл суманд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-д сумын мэргэжлийн ангийн аврах бүлэг, эрүүл мэндийн бүлэг, хэв журам сахиулах бүлэг, механикжуулсан хэсэг, анхны тусламжийн бүлэг, мал эмнэлгийн бүлэг нийт 8 бүлгийн 72 ажилтан, Заамар, Жаргалант, Сүмбэр, Угтаалцайдам 24 бүрэлдэхүүнд танхимын сургалтыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг сурталчилан 4 төрлийн 1024 ширхэг гарын авлага тараах материалыг тараан ажилласан. “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-д Цээл сум 94 хувь буюу “Маш сайн” үнэлгээтэйгээр дүгнэгдсэн.

Онцгой байдлын газрын ангиллын сургалтын төлөвлөгөөний дагуу Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах болон Гамшгаас хамгаалах тухай хуулиар төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн сургалтыг 14 удаа 547 ажилчдад, ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, бага ангийн сургалтыг 15 удаа 876 сурагчдад, иргэний сургалтыг 2 удаа 92 иргэнд, сайн дурын хэсэг, бүлгийн сургалтыг 1 удаа 30 иргэнд танхимын болон дадлага сургалтыг тус тус зохион байгуулж холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлан 8 төрлийн гарын авлага 3129 ширхгийг тараан ажиллалаа.

Аймгийн TBS телевизтэй хамтран 4 дүгээр улиралд цаг агаарын сэрэмжлүүлэх шторк 3, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх шторк 2, орон нутгийн ТӨВ болон TBS телевизэд 6 удаагийн ярилцлага өгч ажилласан байна.

Орон нутгийн TBS телевизтэй хамтран Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар “Цаг агаарын сэрэмжлүүлэх” мэдээлэл, Эрдэнэ суманд байгуулагдсан Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн мэдээллийг Монголын үндэсний телевизээр 21 аймгийн хэмжээнд бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан байна.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье”, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх”, “Объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэрэмжлүүлэх шторкуудыг бэлтгэж байгууллагын пэйж хуудас болон TBS телевизээр ард иргэдэд тус бүр өдрийн 4 удаагийн давтамжтайгаар хүргэн ажиллаж байна.

Мөн цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээг малчид, ард иргэдэд TBS телевизээр дамжуулан тухай бүр өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 52 удаа хүргэлээ.

Байгууллагын фейсбүүк хуудсанд 93 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, вейб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 6 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 16 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 12 удаа нийт 36 удаагийн мэдээ мэдээлийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллаа.

Малын гоц халдварт өвчин: Мялзан өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон-1.

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймэр-3, ой, хээрийн түймрийн дуудлага үгүй, мэдээлэл-2 ирсэн байна.

Онцгой байдлын газраас алба хаагчдын тусгай зориулалтын автомашин, техникийн аюулгүй ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Зуунмод сум дах Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр анги, эрэн хайх, аврах салбарын жолооч нарын дунд "Ажил мэргэжлийн аварга шалгаруулах" тэмцээн зохион байгууллаа.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчин, Газар геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:

Газрын даргын баталсан 19/48 дугаар удирдамжийн хүрээнд Лүн, Өндөрширээт, Бүрэн сумын Засаг дарга, Газрын даамал нарын 2020-2022 оны эхний хагас жилийн газар олголтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хуульд нийцээгүй шийдвэр гаргасан, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтыг зөрчиж олгосон нийт 2 нэгж талбарыг хүчингүй болгох улсын байцаагчийн 6 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын иргэн А. Лувсангийн 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн өргөдөлийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/56 дугаартай удирдамжийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр 7 дугаар зөрлөгийн зүүн талд үйлдвэр үйлчилгээний зориулалттай барилгын ажил гүйцэтгэж байгаа Монголиан хаусинг энд ланд девополмент групп ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 19-04-024/121 дугаартай 2 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр :

Төв аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/631 тоот ажлын хэсэг байгуулах тухай захирамжийн дагуу Заамар сумын нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт ирүүлсэн 13 байршилтай танилцаж, Засгийн газрын 2022 оны 296 дугаартай тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус журмын хүрээнд мэдээлэл, зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан.

Төв аймгийн Прокурорын газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн Төв аймгийн Баянчандмань сумын нутагт байрлах Наранбулаг амралтын газарт холбогдох "Зохих зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон" гэх хэрэгт Зөрчлийн 2234000769 дугаартай хэрэг үүсгэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 2.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч прокурорын хяналтад хүргүүлсэн.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/03 дугаартай "үйлдвэрийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах тухай" удирдамжийн дагуу Жапан стандарт, Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт-д гарсан 2 үйлдвэрийн ослын актыг хянан баталгаажуулж, Төв аймгийн Стандарт хэмжилзүйн газарт гарсан 1 үйлдвэрийн ослыг хянаж байна.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/54 дугаартай удирдамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй Зуунмод суманд Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын "Нэг цэгийн үйлчилгээ бүхий төв, цагдан хорих байр"-ны – 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баян суманд сургуулийн биеийн тамирын заалны – 1, нийт 3 барилга, ашиглагдаж байгаа их эрсдэлтэй үнэлэгдсэн Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилга, Баяндэлгэр сумын цэцэрлэг, ЭМТ-ийн барилгууд, Мөнгөнморьт сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга - 1, Архуст сумын төвд байрлах "Морьт говь-ойл" ХХК-ний шатахуун түгээх станцын 1 байгууламж, Баянжаргалан сумын төвд байрлах "НИК" ХХК-ний шатахуун түгээх станцын байгууламж, Баян сумын цэцэрлэгийн хуучин барилга, "Борхуст хайрхан" ХХК-ний шатахуун түгээх станцын байгууламж, "Тэс петролиум ХХК"-ний шатахуун түгээх станцын байгууламж, Баянцагаан сумын төвд байрлах шатахуун түгээх станцын болох нийт 10 барилга байгууламжууд хамрагдаж, төсвийн 2 барилга байгууламжууд, хувийн

хэвшлийн 6 барилга байгууламжуудын ашиглалтын байдлаас хамааран ашиглалтын төлөв байдлын тухай 2 дүгнэлт, ашиглалтын хэвийн байдлыг хангуулах тухай хамтарсан 6 албан шаардлага, ашиглалтыг зогсоох тухай 2 акт боловсруулж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.

Хяналт шалгалтын танилцуулгыг 2022.11.15-ны өдөр МХЕГ-ын ДБХГ-т хүргүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 212 тогтоолын хүрээнд Газрын даргын баталсан 19/09 дугаартай удирдамжийн дагуу Баян сумын 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн өргөтгөл, Баянжаргалан сумын 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн өргөтгөлийн барилгууд, Сэргэлэн сумын Баянбүрд 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдсан “Таван толгой түлш” ХХК-ийн түүхий эдийн нөөцийн ил талбайн овоолгын хорогдлыг бууруулах байгууламжийн комиссын бүрэлдэхүүнд ажилласан.

Эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын чиглэлээр:

Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн эрүүл ахуйн нөхцөлийн талаар баталгаажуулах хяналтын хийж улсын байцаагчийн 9 дүгнэлт гаргаж, хоолны илчлэгийн -2 удаа, 2 удаа улсын комисст оролцож 1 үүрэг даалгавар хүргүүлж, 1 барилга хүлээж авч ажилласан.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр:

МХЕГ-ын 01/97, аймгийн МХГ-ын даргын 19/50 дугаартай удирдамжийн хүрээнд Цээл, Жаргалант Эрдэнэсант, Сүмбэр, Угтаал цайдам сумдын 10 аж ахуй нэгжийн 2022 онд тариалсан үрийн улаанбуудайн дээжинд мэдрэхүйн аргаар үзлэг хийж 2 аж ахуй нэгжийн 9 дээжийн авч ХАБҮЛЛ-т тарих үрийн чанар, ургамлын өвчин, хортны шинжилгээнд хамруулсан. Одоогийн байдлаар шинжилгээний хариу гараагүй байна.

Сорилтын нэгдсэн лаборатори нь:

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 18 дээжинд 64 үзүүлэлт /Хоолны 2 сорьцонд 11, даршилсан кимчиний 1 сорьцонд 4, гурилан бүтээгдэхүүний 3 сорьцонд 9, гүний усны 11 сорьцонд 33, төвлөрсөн системийн ус 2 сорьцонд 6 / үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 18 сорьцонд 36 үзүүлэлтээр /Гүнийн ус 1 дээжинд 12 үзүүлэлтээр, Хоолны 13 дээжинд 13 үзүүлэлт,архины 1 дээжинд 5 үзүүлэлт,гурилан бүтээгдэхүүн 3 дээжинд 6 үзүүлэлт / эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна.

Ургамлын үр хорио цээрийн лаборатори нь 6 сорьц 18 үзүүлэлтээр Үрийн улаан буудайн /үрийн чанарын шинжилгээг хийж сорилтын үр дүнг хугацаанд нь хянаж баталгаажуулж гаргасан.

Нэгж лабораториудад: нийт 42 сорьцонд 118 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Анхдугаар Үндсэн хуулиа баталсны 100 жилийн ойг угтан “Иргэдийн шударга шүүх” төрийн бус байгууллагаас санаачилсан “Үндсэн хуулийн дугуйлан төсөл”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгууллаа.

“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг угтаж аймгийн Засаг даргын 2022 оны А/661 дүгээр захирамжаар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх өдөрлөгийг 21 хоногийн хугацаатай зохион байгуулж байна. Өдөрлөгөөр хүүхэд залуучуудын дунд “Зурагт хуудас” зохиох, төрийн албан хаагчдын дунд “Мэдээлийн ил тод байдлыг хангахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр эссэ бичлэгийн уралдааныг зарлан иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр постер, подкастыг бэлтгэн цахим орчноор сурталчилж ажиллалаа.

“Олон улсын хүний эрхийн өдөр”-ийг угтаж аймгийн Засаг даргын 2022 оны А/662 дугаар захирамжаар “Эрхээ хамгаалахад хүн бүрийн оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулж байна.

“Албан хэрэг хөтлөлтийн соёлыг дээшлүүлье” сэдэвт аяны хүрээнд аймгийн Музейтэй хамтран архивын нэн үнэт 44000 мянган баримтаас нутгийн захиргааны байгууллагын үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчдын түүхэн гэрэл зураг болон аймгийн 40, 50, 60 жилийн ойн баримтат кино зэрэг дахин давтагдашгүй 223 баримтыг дээжлэн “БАРИМТ ТҮҮХ ӨГҮҮЛЭХ НЬ” сэдэвт үзэсгэлэнг дэлгэж олон нийтэд сурталчиллаа.

Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Архивын ерөнхий газартай хамтран төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарыг хамруулан “Монгол бичгийн цахим бичвэр”-ийн сургалтыг зохион байгуулж 203 албан хаагчийг чадавхжууллаа. Сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Монгол бичгийн цахим бичвэр-2022” уралдааныг зохион байгууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт “Нотариатын үйлдэл хийх арга зүй” сэдвээр цахим сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирамжийн дагуу Баянхангай сумын төсөвт байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийлээ.

ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн архивын эх баримтаас лавлагаа, хуулбар авах хүсэлт ирүүлсэн 85 иргэний хүсэлтийг хүлээн авч 508 хуулбар хувь олгож, 113 лавлагаа, 122 хөмрөгийн 392 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүллээ.

1 хөмрөгийн 17 хадгаламжийн нэгжийн 1010 хуудас баримтын 3970 хүний нэр, 459 заалтын тоо, 459 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 3 хадгаламжийн нэгжийн 364 хуудас баримт скайнердаж 459 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 459 заалтын 1150 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 88 баримтыг хүлээн авч, баримтын тоо бүртгэл хөтлөн хадгаламжийн санд бүртгэж авлаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 64.899 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138.417 газар өмчлөх эрхийн 53.213 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг-1000

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 276.1 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 165.6 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 8.4 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2896 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 29 нэмэлт өөрчлөлт, шинээр 14 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 15, бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 3 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 25 лавлагаа өглөө. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 14.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 662 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 95 хэргээр буюу 16,7 хувиар өссөн, Гэмт хэргийн илрүүлэлт 65 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,8 хувиар өссөн.

Хариуцсан нутаг дэвсгэрт чиглэлийн хамгаалалт 1, зочны хамгаалалт 1, олон нийтийг хамарсан арга хэмжээний 8 хамгаалалтад 98 алба хаагч ажиллаж нийтийн хэв журам сахиулж ажиллалаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 4329 зөрчил илрүүлж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 148 жолоочийг саатуулж холбогдох арга хэмжээг авч, 117 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 31 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4181 жолоочид 111.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 86 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-192, магадлан шинжилгээ-236, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-520, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-1279, гарын хээний санг дардсаар баяжуулсан-709 мөрөөр баяжуулсан-86, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-747, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-222, гистологийн шинжилгээ-236 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
11-р сар	217	708	9	916	584	332	63.7
	4587209.8	3466381.4	178844.7	7874746.5	2957051.5	4917695.0	

**ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу □”Ерөнхий сайдын шуурхай хэрэгжилтийн” 8 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 70 хувьтай ЗГХЭГазарт хүргүүллээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бодлогын 21 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд 11 дүгээр сарын байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Үр дүнтэй- 100 хувьтай-10, Тодорхой үр дүнд хүрсэн- 70-90 хувьтай- 11 арга хэмжээ 92.86 хувьтай ЗГХЭГазарт тайлагнасан.

Аймгийн Засаг даргын нэрэмжит 3 дах удаагийн үзлэгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/658 тоот захирамжаар 27 суманд 9 ажлын хэсэг гарган 2022 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрийн хооронд удирдамжийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн үндсэн үйл ажиллагаа, дотоод ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, үр дүнг үнэлж ажиллалаа.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод БН өрхийн ЭМТ, ГБХЗХГ, аймгийн музей, Насан туршийн боловсролын төв, Аймгийн ИТХ, Нийтийн номын сан, Заамар сумын МСҮТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант, Лүн, Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Заамар, Жаргалант, Сүмбэр сумдын сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Баянцагаан сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Татварын хэлтэс, ОНХ-ийн сан, ЭЭС, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 2020-2022 оны Засгийн газрын хөнгөлөлт, чөлөөлөтөд хамрагдсан Төв чандмань ДЭХГ, Цахилгаан, ус, хог хаягдалд хяналт шалгалт, аймгийн Засаг даргын тусгай удирдамжаар Өндөрширээт сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 5,853,697.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж үүнээс

486,700.5 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 2,180,007.0 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 109,123.0 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 315, 779.9 мянган төгрөгийг тус тус барагдуулж ажилласан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 10-р сарын байдлаар орон нутаг 22203.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 23972.3 сая төгрөг төвлөрүүлж 108.0 хувьтай, 1769.0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 4959.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 6327.3 сая төгрөг төвлөрүүлж 127.6 хувьтай, 1368.2 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 3393.5 сая төгрөгөөр биелж, 110.9 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцагаан, Заамар, Эрдэнэ, Зуунмод зэрэг 6 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал зэрэг 15 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баянхангай, Жаргалант, Цээл, Эрдэнэсант зэрэг 5 сум, 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Сэргэлэн сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад 2022 оны 10 сарын байдлаар нийт 54229.5 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Орон нутгаас Боловсрол шинжлэх ухааны байгууллагад 10462.8 сая төгрөгийн санхүүжилт

-Эрүүл мэндийн байгууллагад 587.3 сая төгрөгийн санхүүжилт

-Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 21377.4 сая төгрөгийн санхүүжилт

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 21802.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2022 оны 10-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 172.3 сая төгрөгийн авлага, 252.2 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 172.0 сая төгрөг буюу 63.1 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 2.8 сая төгрөг буюу 1,04 хувь нь цалингийн өглөг, 1.8 сая төгрөг буюу 0.7 хувь нь НДШимтгэлийн өр, 25.2 сая төгрөг буюу 9.26 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 50.4 сая төгрөг буюу 25.9 хувийг бусад өр эзэлж байна

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.Хөрөнгө оруулалт:Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59,489.7 сая төгрөгийн 97 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс 59,334.7 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурал 2022 оны улсын төсөвт тодотгол хийж баталсантай холбоотойгоор 621.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зогсоосон. Улсын төсвийн эрх шилжүүлсэн ажлаас зогсоосон төсөл, арга хэмжээг хасч тооцвол. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 39,759.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ;
2. Аймгийн Шилжих үлдэгдэлийн хөрөнгө оруулалтын 6,424.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ;
3. Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 2,742.8 сая төгрөгийн 3 ажил;
4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,504.3 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ;
5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1,206.9 сая төгрөгийн 6 ажил;
6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 608.0 сая төгрөгийн 5 ажил;
7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2022 оны эм, эмнэлгийн хэрэглэл худалдан авах 1,600.0 сая төгрөгийн бараа худалдан авах;

8. Гадаадын хөрөнгө оруулалтын 867.0 сая төгрөгийн 1 ажил.
2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 11 дүгээр сарын явцын мэдээлэл: Үүнд:

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ:

Нийт 39,759.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнээс 11 дүгээр сарын байдлаар захиалагч байгууллагад 39,739.7 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээнд 38,408.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Уг гэрээ байгуулагдсан ажилд нэмэлтээр 11 дүгээр сарын 04-нд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлын 256.9 сая төгрөгийн гэрээ мөн байгуулагдсан.

-Соёлын яамнаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн аймгийн Нийтийн номын санд 20.0 сая төгрөгийн бараа нийлүүлэх тендерт шаардлага хангасан оролцогч оролцохгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нийт 7 удаа зарласан. Нээлтийг 2022.12.02-нд зохион байгуулна.

1.2 Аймгийн шилжих үлдэгдлээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

11 дүгээр сарын байдлаар 3,254.6 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрхийг захиалагчдад хүргүүлсэнээс 19 ажилд гэрээ байгуулагдаж, дараах 2 төсөл, арга хэмжээг тодруулан тайланд тусгав. Үүнд:

1. Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал (Батсүмбэр сум) 100.0 сая төгрөгийн ажилд Монголиан дижитал скүүл ХХК шалгарч гэрээ байгуулах шатанд;

2. Хүнсний зах орчмын гадна дулааны шугам засвар шинэчлэлийн ажил (Зуунмод, Номт баг) 57.6 сая төгрөгийн ажилд Мөнхчандмань илч ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгосон боловч захиалагчтай гэрээ байгуулаагүй, тендерээсээ татгалзсан байна.

-Шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх аймаг, сумын Онцгой комисс, шуурхай штабын авто машин шинэчлэх зардал (БОАЖГазар) 70.0 сая төгрөгийн тендерийг нийт 8 удаа зарлаж сүүлд зарласан тендерийн нээлтийг 2022.11.21-нд зохион байгуулахад 5 компани оролцсон -ҮХороо үнэлгээ хийж ажиллаж байна.

-Сумдад эрх шилжүүлсэн Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал (Бүрэн сум) 100.0 сая төгрөгийн ажлыг эрх хүлээж авсан сумын ЗДТГ-аас нийт 4 удаа зарлаж тендерийн нээлтийг 2022.11.25-нд нээхээр ажиллаж байна.

-Шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх аймгийн Нутгийн удирдлагын ордны өргөтгөл, их засварын ажлыг эхлүүлэх 3,000.0 сая, төгрөгийн ажлын тендерийн дахин зарлахаас 2022.11.25-ны байдлаар захиалагч байгууллагаас зарлуулах шийдвэр ирээгүй байна.

1.3 Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-11 дүгээр сард Төвийн авто зам дагуу явган хүний зам барилгын ажил 400.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж 4 компани оролцож үнэлгээний хороо шалгаруулалтын бүрэн гүйцэтгэж захиалагч аймгийн БЗОСК ОНӨААТҮГазарт үнэлгээний хорооны дүгнэлтийг 2022.10.17-нд цахим системд үр дүнг нийтлэж ажлын 6 хоног хүлээсэн, гомдол гараагүй тул захиалагч гэрээг шалгарсан компанитай байгуулсан.

Замын сангаас 2,742.6 сая төгрөгийн 3 ажилд тендерийг зарлаж уг 3 ажилд 640.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Худалдан авах ажиллагаа 100 хувь зохион байгуулагдсан.

1.4 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-ОНХСангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 11 дүгээр сарын байдлаар захиалагч байгууллагад нийт 4,719.4 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрхийг олгосноос 28 ажилд гэрээ байгуулагдаж 1 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдахаар хүлээгдэж байна.

-Сумдад эрх шилжүүлсэн ажлаас Баянцагаан сумын Гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг халаалтад холбох 80.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг дахин зарлахаар захиалагч шийдвэрлэсэн. 2022.11.25-ны байдлаар зарлагдаагүй байна.

1.5 Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 1,206.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 6 ажилд 1,161.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

1.6 Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

-Нийт 608.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 517.0 сая төгрөгийн 4 ажил, захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан. Тендер шалгаруулалт 100 хувь.

1.7 Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын Эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 32 багцад шалгаруулалт хийж, гэрээ байгуулагдсан.

1.8 Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ:

Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарласан. Шинэчлэл-инвест ХХК шалгарч 850.5 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

ХОЁР. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР

2.1 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 сарын 26-ны өдрийн 52 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 07 сарын 20-ны өдрийн А/396 дугаар захирамжаар хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох санал, холбогдох материал, өмч хамгааллах байнгын зөвлөлийн дүгнэлт хурлын тэмдэглэлийг тус тус судлан үзэж нийт 9 байгууллагын 618,2 сая төгрөгийн хөрөнгийн үнэ болон хугацааг шинэчлэн тогтоосон.

2.2 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгийн улсын үзлэг тооллогын нэтгэлийг авч байгаатай холбогдуулан Засгийн газрын хурлаар оруулах материалд нэмэлтээр дараах судалгааг гаргах ажил хийгдэж байна.

- Барилга байгууламжийн цахим бүртгэл хийгдэх гэж байгаатай холбогдуулан орон нутгийн өмчит байгууллагуудын барилгад гэрчилгээ олгох ажлын хүрээнд барилгын цэвэр дүн гаргах
- 2016 оны тооллогоос 2021 онд худаг услалтын систем хэдээр нэмэгдэж хэдээр хасагдсан цэвэр дүн гаргах
- 2018 оны газрын үнэлгээнээс 2021 оны тооллогоор газар нэмэгдсэн үнэлгээ хийдсэн дүн гаргах
- Хуулийн этгээдийн мэдээлэл тулгах
- Өөрийн байргүй байгууллагын судалгаа гаргах
- Орон нутгийн өмчит компаний хувцааны лавлагаа гаргах
- Хэмнэлтийн тухай хуулиар хэрэгжүүлсэн ажлын тайлан гаргах
- Геодиз зураг зүйн цэг тэмдэгтийн судалгааг эцэслэж гаргах
- Бүртгэлгүй, маргаантай дутагдуулсан, илүүдэлтэй хөрөнгийн судалгааг нэгтгэн гаргах зэрэг ажлуудын нэмэлт сулагаа тайланг нэгтгэж байна.

2.3 2021 оны эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын илтгэх хуудас, тогтоолын төслийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлд өргөн барьсан.

ГУРАВ. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

3.1 Хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд:

- Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын зөвлөлийн 2022.11.23, 2022.11.28-ны хурлаар хэлэлцүүлсэн асуудал
 - Зуунмод хотын 3 дахь ээлжийн орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
 - Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
- “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн боловсруулсан талаарх танилцуулга, хэлэлцүүлгийг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн а/293 дугаар захирамжаар аймгийн дэд ажлын хэсэг нь Барилгын хөгжлийн төвтэй хамтран аймгийн ИТХ, иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг 2022.11.29-ний өдөр зохион байгууллаа.

3.2 Барилга захиалагч, хяналтын чиглэлээр: 2022 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 46 төсөл арга хэмжээ төсөвт өртөг 91,307.1 сая төгрөг, 2022 онд 26,285.7 сая төгрөг санхүүжих дүнтэй ажилд захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

- 2022 онд улсын хөрөнгө оруулалтаар 20 барилга байгууламж 27,0 тэр бум төгрөг
 - 1. Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлууд:

- Ашиглалтад орсон.

- Баяндэлгэр сумын сургууль, Цээл сумын дотуур байрны ариун цэврийн байгууламж байгуулах ажил
- Жаргалант Талбулаг баг сургууль, цэцэрлэг, Загдал баг сургууль, Баянцогт сумын сургууль, Сэргэлэн сумын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн ажил
- Дулааны станцын халаалтын 1,2,3,4,5,6,7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил, 7-р хэсгийн 347м шугам сүлжээ
- Монголын үндэсний археологи, палентлоги, угсаатны зүйн музей, лабораторийн 1-3-р давхрын цутгалт
- Зуунмод сумын үерийн ус зайлуулах байгууламжийн ажил 1, 2-р багц
- Зуунмод сумын цэвэр усны 1, 3-р өргөх насосны станцын шинэчлэлт
- Зуунмод хотын цэвэр усан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний ажил
- Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор /Төв, Зуунмод сум/ “Клай Макс Интернэйшнл” ХХК Суурь, зоорийн давхрын цутгалт угсралтын ажил
- Эрдэнэ сумын Эрүүл мэндийн барилга угсралтын ажил карказ цутгагдаж, өрлөг
- Жаргалант сумын спорт заалны барилга гүйцэтгэгч Сэрвэн овоот ХХК 1383,6 сая төгрөг гэрээ байгуулсан. Газар шороо, суурийн ажил хийгдсэн.
- Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төслийн хүрээнд 5 суманд төсөл хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагууд шалгарч ажил гэрээт ажлын тоо хэмжээний дагуу 2022 онд хийх ажил бүрэн хийгдсэн.
- Борнуур суманд Бохир усны шугамын ажил 824.8 м шугам угсарсан, цэвэр усны 150 м шугам угсарсан, цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэж байна.
- Сэргэлэн суманд ариутгах татуургын шугамын ажил 100 хувь хийгдсэн, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажил хийгдсэн
- Эрдэнэ суманд 2 худгийн угсралтын ажил дууссан, цэвэр усны шугамын угсралтын ажил хийгдэж байна. Ус хангамжийн ажлын бүрэн дууссан.
- Баянчандмань суманд 2 худгийн барилга, усны нөөцийн сангийн суурийн нүх, цахилгаан хангамжийн ажил хийгдсэн.
- Дэлгэрхаан суманд цэвэр усан хангамжийн шугам угсралтын ажил хийгдэж дууссан. Өндрийн усан сан болон одоо байгаа шугам сүлжээнд холбох ажил хийгдэж дууссан.

2. Ажил хийгдэж байгаа

- Бүрэн сумын сургуулийн барилга угсралтын ажил Барилга угсралтын ажил дууссан. Гадна цахилгаан, шал, дотор заслын зарим ажлуудыг хийж дуусгахаар ажиллаж байна.
- 2000 айлын орон сууцны хорооллын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/. Дулаан хангамжийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж байна.
- Зуунмод хотын 1500 айлын орон сууцны хороолол шугам сүлжээ байгуулах ажил эхэлсэн. Зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар :

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжиж байгаа 5 төсөл арга хэмжээ, шинээр 4 ажил хийгдэж байна.

- Аймгийн ЗДТГ-ын өргөтгөлийн барилга, их засварын ажлын зураг төсөл боловсруулах ажил тендер зарлахаар бэлтгэл хангаж байна.
- Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэн болон айл өрхийн суурьшлын хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам хоолойн ажил бүрэн дууссан.
- Бүрэн, Сүмбэр / Сүмбэр сумдын ногоон байгууламжийн ажлыг Баян Эрхэт гүн ХХКомпани 2022.09.14-нд ашиглалтад оруулах комисс ажиллан ашиглалтад оруулсан.
- Өвсний үндэс хөтөлбөр, Хүмүүн цогцолбор сургуулийн А байрыг шинэчлэн засварлах /Төв, Зуунмод сум/ ажил бүрэн хийгдэж хүлээлгэн өгсөн .

Хот байгуулалтын чиглэлээр:

- Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийн дагуу Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 80 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 4 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.
- Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд 2022 онд 170 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Энэ сард 14 зураг төсөл батлаад байна.
- Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 94 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгосон ба энэ сард 24 гүйцэтгэлийн зураг хүлээн авсан.

Засгийн газрын 2021 оны 212, 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд :

- Барилга эхлүүлэх зөвшөөрөл энэ онд нийт 113 барилга байгууламжид олгон энэ сард 11 барилга байгууламжид олгосон байна.
- Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ онд нийт 72 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан ба энэ сард 16 барилга байгууламж ашиглалтад орсон.

ДӨРӨВ. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

4.1 Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Газар зохион байгуулалт, хот байгуулалтын цахим системд 27 сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 10192 нэгж талбар 296130.31 га талбай төлөвлөснөөс газар чөлөөлөх 12 нэгж талбар 6369,23 га, нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт 33 нэгж талбар 4467,38 га, дуудлага худалдаагаар 284 нэгж талбар 1121,47 га газар төлөвлөснөөс 31 нэгж талбар 67,3 га, төсөл сонгон шалгаруулалтаар 25 нэгж талбар 689,32 га газар төлөвлөснөөс 2 нэгж талбар 400,14 га, газар өмчлөл 6240 иргэнд 1525,311 га газар төлөвлөснөөс 247 иргэнд 49,07 га, гэр бүлийн хэрэгцээ, зуслан , төсөвт байгууллага, давуу эрхээр 3554 нэгж талбар 14373,969 га газар төлөвлөснөөс 2753 нэгж талбар 4987,113 га газрыг олгож, бүртгэсэн байна.

4.2. Суурь судалгаа газрын мониторингийн ажлын хүрээнд: Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна.2022.10.01-ний өдрийн байдлаар 206 мэдэгдэл хуудас хэвлэж өгсөнөөс 165 хянан баталгааг цахимаар ирүүлсэн байна.Үүнээс: баталгаажуулсан төлөвтэй 145, Илгээх буюу шинээр ирүүлсэн 15, хянасан буцаасан төлөвтэй 5 тайлан тус бүр байна.

4.3. Газрын төлбөр: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг Батсүмбэр 3, Борнуур 3, Сүмбэр 5, Сэргэлэн 2, Эрдэнэ 1, Эрдэнэсант 2 нийт 16 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг www.mle.mn сайтад баталгаажуулж зарласан.

Газрын дуудлага худалдааны орлого өссөн дүнгээр 3,0 тэрбум төгрөг газрын биржийн 100140000967 дансанд төвлөрч “Дуудлага худалдааны орлогыг хуваарилах, зарцуулах, тайлагнах журмын” дагуу сумдад шилжүүлсэн.

2022.11.28 өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 2,11 тэрбум төгрөг аймаг сумын дансанд төвлөрүүлсэн байна.

4.4. Газрын кадастрын чиглэлээр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2 сарын хугацаанд зарласан аян, 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр нөхөн бүрдүүлэлт хаах болсонтой холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны хооронд Б.Батбаяр, Б.Ууганцэцэг, Ч.Наран, Ц.Бямбасүрэн, Б.Бадамгарав, М.Цогжавхаа, Б.Бат-Оргил болон 16 сумын газрын даамлыг хамруулсан ажлын хэсэг Баянцогт, Аргалант, Баянхангай, Лүн, Баян, Баянжаргалан, Архуст, Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Алтанбулаг, Сэргэлэн сумдад ажиллаж 2022 онд нийт 12025 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлт хийлээ.

Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь газрын харилцааны цахим системийг сурталчлах, үйлчилгээний чанарыг сайжруулах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр санаачлага гарган ажилласаар ирсэн. 2022 онд иргэдэд цахим систем, egazar.gov.mn-ээс үйлчилгээ авах тухай 15 танилцуулга видеог аймгийн олны

танил эрхмүүдийг оролцуулан сурталчилж, 19 суманд нээлттэй өдөрлөгийг 24 удаа зохион байгуулж, 27 сумын нөхөн бүрдүүлэлтийн ажлыг үе шаттай зохион байгуулж, 2017 онд Ланд менежер нэвтрэхэд нийт 27984 нэгж талбартай байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 92041 нэгж талбартай буюу 64057 нэгж талбарыг нэмж бүртгээд байна.

Геодези зураг зүйн чиглэлээр:

Алтанбулаг, Сэргэлэн, Баянцагаан, Заамар сумдын стандарт шаардлага хангасан биологи болон техникийн нөхөн сэргээлт хийсэн. Аж ахуй нэгжүүдийн нөхөн сэргээлтийг хүлээн авч хэмжилт зураглал хийсэн. Үүнд Биологийн-277.06 га Техникийн-480.26 га Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайд байгаль орчин хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгуулан 152.29 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийлгэж хүлээн авч мэдээллийн санд оруулсан.

ТАВ. ЗАМ ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

А0201 дугаартай Улаанбаатар- Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын 70-80 км-т зорчих хэсэгт тогтсон

- 200мм зузаантай нягтарсан цасыг автогрейдерээр хусаж цэвэрлэсэн 175000 м²
- Зорчих хэсгийн хальтиргаан дээр машин дээрээс гараар бодис цацсан 80000 м²
- Зорчих хэсэгт тогтсон 200мм сийрэг цасыг шүүрдэгч машинаар 110000м² зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэж цэвэрлэсэн.

А25 дугаартай Өндөрдов- Зуунмод- Налайх чиглэлийн хатуу хучилттай авто замын 0,00-29 км-т зорчих хэсэгт шуурч тогтсон

- 200мм зузаантай нягтарсан цасыг автогрейдерээр хусаж цэвэрлэсэн 80000м²
- Зорчих хэсгийн хальтиргаан дээр машин дээрээс гараар бодис цацсан 45000 м² зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэж цэвэрлэсэн.

Төв аймгийн зуунмод сумын хатуу хучилттай авто замын зорчих хэсэгт шуурч тогтсон

- 200мм зузаантай нягтарсан цасыг автогрейдерээр хусаж цэвэрлэсэн 12000 м²
- Зорчих хэсгийн хальтиргаан дээр машин дээрээс гараар бодис цацсан 7000 м²
- Зорчих хэсэгт тогтсон 200мм сийрэг цасыг шүүрдэгч машинаар цэвэрлэсэн 11000м²

зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэсэн цэвэрлэсэн.

ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Газар тариалангийн хүрээнд : 2022 онд нийт 118.0 мян.га талбайд тариалалт хийж, 308.0 мян.тн. ургац хураан авлаа. Үүнд:

• Үр тариа: 57083 га-с 68798.2 тн, нэгжийн ургац 12 цн, Үүнээс улаанбуудай 50061 га талбайгаас 58361.6 тн, нэгжийн ургац 11.7 цн

- Төмс: 12160 га-с 134912 тн, нэгжийн ургац 111 цн
- Хүнсний ногоо: 1910.8 га-с 24458 тн, нэгжийн ургац 128 цн
- Таримал тэжээл: 21538 га-с 70546.9 тн, нэгжийн ургац 33 цн
- Тосны ургамал: 24333 га-с 8724.3 тн, нэгжийн ургац 3.6 цн
- Жимс, жимсгэнэ: 277 га-с 105 тн

Аймгийн хэмжээнд 1609 иргэн, 104 аж ахуйн нэгж хүнсний ногооны тариалалт хийж, 1094 иргэн, 41 аж ахуйн нэгжид 50,0 сая төгрөгийн өргтөг бүхий 11 нэр төрлийн 17543 кг төмс, хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр, төмс, ногооны 259.8 сая төгрөгийн үрийн дэмжлэг үзүүлээ.

Үүний үр дүнд 2021 оноос хүнсний ногоо тариалсан талбай 421 га, ургац 3334 тн-оор, төмс тариалсан талбай 1273 га, ургац 31227 тн тус тус өслөө.

Мал аж ахуйн хүрээнд: Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажил аймгийн хэмжээнд 86.0 хувьтай хангагдлаа.

Манай аймгийн Аргалант, Баянцагаан, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Цээл, Угтаалцайдам, Заамар, Борнуур сумын нутаг дэвсгэрт Завхан, Дундговь, Өвөрхангай, Говь-Алтай, Увс, Баянхонгор, Хэнтий, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотын нийт 119 өрхийн 111.3 мян.толгой мал отроор өвөлжиж байна.

Аймаг дундын отрын бүс нутаг манай аймгийн 32 өрхийн 31319 толгой мал отроор өвөлжиж байна. Үүнд:

- Хэнтий аймгийн Хэрлэнбаян Улаан: 16 өрх 17784 толгой
- Говьсүмбэр аймгийн Малхын тал: 5 өрх 5021 толгой
- Булган аймгийн Хөх Чилэнг: 11 өрх 8514 толгой

Аймгийн аюулгүйн нөөцөд өвс 250 тн, тэжээл 125 тн бэлтгэж 100 хувь, сумын аюулгүйн нөөцөд өвс 16168 тн буюу 74.8 хувь, тэжээл 869 тн буюу 64.3 хувийн хангалттай байна.

Малчид, мал бүхий иргэдийг өвс, тэжээл бэлтгэл ажлын хүрээнд малчин, мал бүхий иргэд 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 94255.1 тн хадлан, 14933.6 тн гар тэжээл, 46728.2 тн ногоон тэжээл, 8319.2 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэж, малчин, мал бүхий иргэдийн өвс, тэжээл бэлтгэл 73.7 хувийн хэрэгжилттэй байна.

Малын үүлдэр угсаа сайжруулах зорилгоор 17 сумын 2035 толгой үнээд зохиомол хээлтүүлэг, 4 сумын 14481 толгой үхэр сүргийг ээмэгжүүлэх ажлыг тус тус зохион байгуулж мал аж ахуйн нэгдсэн санд бүртгэлжүүлээ.

Мал, амьтны эрүүл мэндийн хүрээнд: Малын эрүүл мэндийн үзлэгт 4100.0 мян.тол мал хамруулахаас 4205.4 мян.тол мал хамруулж 102.5 хувь, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 4 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 7943.2 мян.тол мал хамруулахаас 7963.0 мян.тол мал хамруулж 100.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гоц халдварт бог малын мялзан өвчин Баян-өнжүүл суманд 1 голомтод оношлогдон 1 өрхийн 7 мал устгаж хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна

Тайлант хугацаанд 41571 мал, амьтан, 2731.1 тн мах, махан бүтээгдэхүүн, 3337 ширхэг арьс шир, 2047.6 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 56.3 тн дайвар бүтээгдэхүүнд 8548 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 24 дуудлагын дагуу 966 малд үйлчилгээ үзүүллээ.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны хүрээнд: Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, Аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга болон баялаг бүтээгчид 250 төлөөлөл оролцож, газар тариалангийн үйлдвэрлэлийн 2022 оны шилдэг аж ахуйн нэгж, иргэдийг шагнаж урамшууллаа.

Аймгийн жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэгчээр хэрэглэгчдэд шууд хүргэх зорилгоор “Нэг сум-Нэг бүтээгдэхүүн -2022” үзэсгэлэн худалдааг “Шинэ мах-Шинэ сүү-Шинэ сүү” уриан дор Зуунмод суманд зохион байгуулж, 254 аж ахуйн нэгж, хоршоо, иргэн үйлдвэрлэл эрхлэгчид 250 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 2.2 тэрбум төгрөгийн борлуулалтаар дэмжигдлээ.

Обихиро ЖАЙКА олон улсын байгууллага, ШУТИС-ын Бизнесийн Ахисан Түвшний сургууль, Японы Хоккайдо мужийн Токачи ХАА-н машин механизмын нийгэмлэгтэй хамтран “Хоршооны үйл ажиллагаанд гэрээт менежментийг нэвтрүүлэх нь” Монгол-Японы хоршоологчдын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Монгол банк Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазар, Монголын Хоршоологчдын Нэгдсэн холбоо, Монголын үхэр үржүүлэгчдийн Нэгдсэн холбоо болон хоршооны төлөөлөл 200 иргэн оролцлоо.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээний хүрээнд: Зуунмод, Аргалант, Батсүмбэр, Баянчандмань, Сэргэлэн сумдын 19 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, үйлчилгээнийг баталгаажуулах тохирлын үнэлгээнд хамрууллаа. Жаргалант, Сэргэлэн, Зуунмод сумын нүүрс олборлолт, тээвэрлэлт болон худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэлийн хэмжлийн 2 төрлөөр 107 хэмжих хэрэгсэл, Ник петровис, Тэс петролиум, Мон суль ХХК-ны орон нутаг дахь Шатахуун түгээх станцын хэмжих хэрэгсэлийг хянан баталгаажууллаа.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

7.1. Орчны бохирдолын талаар: Гэр хорооллын өрхийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн сав байрлуулах ажил Эрдэнэ, Батсүмбэр сумдад хийгдсэнээр нийт 6 суманд 400 ширхэгийг хүлээлгэн өгч, байрлуулж дууслаа. Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2022 оны 11 болон 13 дугаарт албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 04-ны өдрийн 05 дугаарт “Нүхэн жорлонгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” албан даалгавар гарч, сумдыг хэрэгжүүлэх чиглэл өгч ажиллаа. Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 10-ны өдрийн А/645 дугаар захирамжаар “Агаар блхирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах тухай” шийдвэр гарч, зохион байгуулах ажлын хэсэг, удирдамж батдагдсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 10-ны өрийн А/646 дугаар захирамжаар аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн нийтийн эзэмшлийн газарт ангилан ялгах сав байршуулах бараа худалдан авах ажлыг зохион байгуулах ажлыг Зуунмод суманд нь эрхийг шүлжүүлэн гүйцэтгүүлэх шийдвэр гарч, хэрэгжүүлэн ажиллаж байна. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй

“Ананд биотехнологи” ХХК-ны үйл ажиллагаанд “Монголын алт” ХХК-наас аймгийн Засаг даргад ирүүлсэн саналыг үндэслэн, Байгаль хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, стандартын хэрэгжилтийн хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, тухайн орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, шалгалтын зорилгоор 2022 оны 11 сарын 17-ны өдөр Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар /Экологийн цагдаагийн алба, зөвшилцсөнөөр/-ын хамтарсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, үйл ажиллагааг түр зогсоохоор шийдвэрлэсэн.

7.2 Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд:

Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баянхангай, Баянчандмань, Өндөрширээт, Угтаалцайдам, Цээл, Зуунмод, Сэргэлэн, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан зэрэг 15 сумдын 667 усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг зохион байгуулж, Засаг даргын зөвлөл, ИТХ-ын зөвлөлд хэлэлцүүлж ажилласан. Журмын дагуу зураглал хийхэд усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс 172406 га, энгийн хамгаалалтын бүс 262294 га буюу нийт хамгаалалтын бүсийн талбайг 434700 га талбайгаар тогтоон боловсруулсан.

7.3. Биологийн төрөл зүйлийн ажлын хүрээнд: 2023 онд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо толгойн хэмжээ, тооцоо судалгааг нэгтгэж Байгаль орчин, Аялал Жуулчлалын яамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд ховор амьтан, ургамлыг тархац нутгаар нь орон нутгийн хамгаалалтад авах ажил зохион байгуулагдлаа.

Сумдын ИТХ-аас ирүүлсэн санал, 2020 онд хийгдсэн аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа, ургамлын байршиц, тархац нөөцийг тогтоох судалгаанд үндэслэн, аймгийн хэмжээнд 19 сумын 16 байршилд, нийт 349611 га газар авахаар санал боловсруулан, аймгийн ИТХ-д танилцуулж батлуулсан. 2022 онд аймгийн хэмжээнд Дэлгэрхаан, Сэргэлэн, Баян зэрэг сумдаг шонхор шувуу барих отог байгуулагдсан. 2022 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр Баян сумын нутаг дэвсгэрт байгуулагдсан шонхрын отогт хяналт шалгалт хийлээ. Баян сумын нутаг дэвсгэрээс 4 толгой идлэг шонхор барих гэрээ байгуулж акт бичигдсэн бөгөөд агнуурын нөөц ашигласны төлбөр болох 122,076,000 төгрөгийг бүрэн төлсөн байна. Аймгийн хэмжээнд идлэг шонхор бариулсны төлбөрийн орлого 1,045,549,800 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

НАЙМ. УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

8.1. Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7,10 хоног тутмын цаг агаарын тойм, энэ сарын нарийвчилсан анхааруулах мэдээ 24-ний өдөр 1 удаа, хоногийн анхааруулах мэдээ 10, 17, 18, 23, 24-ний өдрүүдэд 5 удаа цас орж, зарим газраар цасан шуурга шуурч, салхи шуургатай байхыг анхааруулсан. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээг 18, 24-ний өдрүүдэд 2 удаа, хоногийн нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээг 18-ны өдөр 1 удаа цасан шуурганы сэрэмжлүүлэг мэдээг гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsagiug page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна.

8.2. Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна.

Агаарын чанарын ажиглалтыг 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 51 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн багаж эвдэрсэн тул хэмжилт хийгдэхгүй байгаа азотын давхар ислийн дундаж агууламж 0.027 мг/м³ үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад азотын давхар ислийн дундаж агууламж 0.016мг/м³-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 11 дүгээр сард Туул-Лүн, Туул-Заамар голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 285 uS/cm, Туул-Заамар 366 uS/cm, тус тус гарлаа.

8.4. Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 133 см, Хэрлэн-Мөнгөнморьт 115 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 532 см, Туул-Лүн харуулд 117 см, Туул-Заамар харуулд-185 см, Сөгнөгөр-Сөгнөгөр 178 см, Шивэрт-Борнуур 141 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуулууд 20 см их, Туул голын дагуух Туул-Алтанбулаг, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 4-24 см бага, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 18 см бага, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 5 см их байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХҮРЭЭНД:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 1а/5063 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын А/641 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг тусгай удирдамжаар Эрдэнэ сум дахь МСҮТ-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, хийж тайлан мэдээг хүргүүлсэн.
2. Италийн-Айфо төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр Тэгш дүүрэн хөтөлбөрийг хэрэгжүүлж тус хөтөлбөрийн хүрээнд 100 толгой ямааг Баянцагаан сумаас Баян-Өнжүүл суманд шилжүүлэн хүлээлгэж өглөө.
3. Коронавируст халдвар /Covid-19/ болон томуу, томуу төст өвчин, амьсгалын замын бусад халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын 01/1906 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна.
4. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, 2022 онд бүртгэгдсэн эхийн эндэгдлийн тохиолдлыг магадлан хэлэлцэх ЭХЭМҮТ-ийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хугацаатай үүрэг чиглэлийг ЭМГ-ын даргад хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавин, хамтран ажиллаж байна.
5. Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгээр 27 сумын нийгмийн салбарын байгууллага, мэргэжилтнүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, зөвлөн тусалж ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

1. Аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын байдлаар 659 эх төрж, өмнөх оны мөн үеэс 303 тохиолдлоор буурсан ба 664 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад нийт 731 эмэгтэй байна, 1102 жирэмсэнг шинээр хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 92.74% хамрагдсан. Нийт 282356 хүнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 102559, амбулаторийн үзлэг 147320, идэвхитэй хяналтын 22140 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 14262 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 24.60%, осол гэмтлийн дуудлага 2.78%-ийг эзэлж байна. Стационарт 14153 хүн эмчлэгдэн нийт 103921 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,3 байна.
2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2022 оны 11 сараас 24 цагийн холтер зүрхний цахилгаан бичлэг хийж эхэллээ.
3. 26 сумын Эрүүл мэндийн төвд төлөвлөгөөт ХШҮ хийж албан тушаал бүрээр 2022 оны ажлыг дүгнэж, зөвлөн туслав
4. Эрүүл мэндийн газар Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартын 2-р магадлан аудитад амжилттай хамрагдаж, гэрчилгээг сунгах болзол биелүүллээ.
5. Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан 425,516,320 төгрөгний нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хуваарилагдсан 104,830,000 төгрөгний үнэ бүхий 10000ш ковид-19-ын түргэвчилсэн оношлуур татан авсан.
6. Эрүүл мэндийн сайдын А/179, А/180 тоот тушаалын дагуу "Өвөржанчивлан" ХХК-ны "Өвөржанчивлан" рашаан сувилал, "Намдүү" ХХК-ны "Задгай цагаан" рашаан сувилал, Архуст, Заамар, Лүн сумын Эрүүл мэндийн төвүүд магадлан итгэмжлэлд хамрагдсан.

7. 2022 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн байдлаар Коронавируст халдвар /Ковид-19/-тай 133 иргэнийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулсан, эмчлэгдсэн 65, нас баралт 0, одоогоор 68 иргэн эмчилгээнд хамрагдаж байна.
8. 26 сумын Эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн нөхцөлд дэлгэсэн нийт 343 ор дэлгэхээр төлөвлөсөн. Үүнд: Халдвартын тасагт-95, энгийн тасагт-248 ор дэлгэхээр төлөвлөсөн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг өнөөдрийн байдлаар 22 ор дэлгэн ажиллаж байна. Цаашид өвчлөл нэмэгдвэл орыг төлөвлөгөөний дагуу 130 хүртэл дэлгэн ажиллана.
9. Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгээр сүрьеэгийн хавьтлын эрт илрүүлэг үзлэгт Алтанбулаг, Баянхангай, Баянхангай, Аргалант, Баянцогт, Өндөрширээт, Эрдэнэсант сумын зорилтот бүлгийн 742 хүн хамруулж сүрьеэгийн 5 тохиолдол илрүүллээ.
10. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн 27 сумын хэмжээнд 15-60 насны 420 иргэнээс “Коронавируст халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох” асуумж судалгааг авч ажиллаж байна.
11. Улирлын томуугийн дархлаажуулалтын үйл ажиллагаа зохион байгуулж, аймгийн хэмжээнд эрсдэлт бүлгийн хүн амд хийгдэх 12810 хүн тун томуугийн эсрэг вакцин татан авч, хуваарилсан, вакцинжуулалтын хамралт 50 хувьтай байна.
12. Аймгийн хэмжээнд халдварт өвчний 11 тохиолдол илэрч тандалт хариу арга хэмжээг гүйцэтгэн ажилласан. Үүнд: Тууралтат халдвар-5, Гэдэсний халдвар-6
13. ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ОЮУТАН” оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Эрдэнэ, Батсүмбэр, Заамар сумын Политехникийн коллежийн 232 оюутныг урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулж БЗДХ-ын түргэвчилсэн шинжилгээ хийхэд 4 эерэг гарсан, эмчийн хяналтад оруулан эмчлэгээнд хамруулж байна.
14. Орчны эрүүл мэндийн лабораторид нийт 322 сорьцод хими, нян судлалын шинжилгээ хийж гүйцэтгэсэн. Стандартын шаардлага хангаагүй сорьцод дүгнэлт хийж, зөвлөмж хүргүүлсэн
15. 3 байгууллагад танхимын сургалт зохион байгуулж 370 ажилтан албан хаагчид, чадавхжуулах сургалт 2 удаа 120 эмч эмнэлгийн мэргэжилтэн, бүсчилсэн сургалт 4 бүсээр 100 эмч, цахим сургалт 4 удаа 124 эмнэлгийн ажилтан, нийт 13 удаагийн сургалтад 714 хүн хамруулсан.
16. “Архигүй амьдралыг цогцлооё-2” цахим аян зохион байгуулахыг уриалж байгууллагын цахим хаягаар 18 төрлийн постер мэдээлэл түгээн ажиллаж байна.
17. Хүмүүн, Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 50 гаруй багш ажилчдаас бие бялдрын түвшин тогтоох сорил авч, биеийн жингийн индекс тодорхойлж илүүдэл жин, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хэрхэн бууруулах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.
18. “ХОРОМ БҮРЭЭ АНХААРЬЯ-3”сэдэвт иргэдийг осол гэмтлээс сэргийлэх аян зохион байгуулагдаж байна.
19. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн алба, тасгийн ахлах сувилагч нар Дархан хотын Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албаны үйл ажиллагаатай танилцаж, туршлага судаллаа.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД:

6. Монголын Тусгай Олимпын хорооны төлөөлөгчид хүрэлцэн ирж хөгжлийн хоцрогдолтой сурагчдыг дэмжих, урам зориг өгөх зорилгоор уулзалт ярилцлага, спортын үзүүлэх тоглолт хийж цаашид хамтран ажиллахаар боллоо.
7. Боловсрол шинжлэх ухааны яамнаас санаачлан хэрэгжүүлж буй "Иргэдийн инновацийн санаачилгыг дэмжих Мон-Х" хөтөлбөрийн хүрээнд Төв аймгаас нийт 75 төсөл илгээснээс Угтаалцайдам сумын газрын даамал Н.Мөнгөнтуяа, архив бичиг хэргийн ажилтан Н.Онон, Эрдэнэсант сумын МУИС-ын II-р курсын оюутан С.Жамсрандорж нарын төсөл эхний шатанд шалгарлаа.
8. Орчин үеийн Боловсролын Технологийн Төв, Улаанбаатар дахь Орос Ордон хамтран Орос хэлний багш нарын ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийн сургалтыг Монголд зохион байгуулан, аймгийн 13 багш хамрагдаж, сертификат авлаа.
9. Монгол улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам” 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай” 2022 оны А/368 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын Хүүхдийн цэцэрлэгийн

- багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам” 2022 оны А/430 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх үнэлгээ”-г зохион байгуулж нийт 39 цэцэрлэгийн багш хамрагдсан бөгөөд үр дүнг хувь багш бүхэнд хүргүүлсэн.
10. Боловсролын үнэлгээний төвөөс батлагдсан удирдамжийн дагуу “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ”-г зохион байгуулж, 30 ерөнхий боловсролын сургууль, 38 цэцэрлэг өөрийн үнэлгээний багаа томилон, 6 шалгуур 8 үзүүлэлтээр үнэлгээний түүвэрт хамрагдсан багш, сурагчид, эцэг эх асран хамгаалагчид цахим системээр асуулгад хамрагдсан.
 11. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээний тухай А/200 дугаар тушаал, ерөнхий боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт 2 төлөөлөл оролцлоо.
 12. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт хамтарсан багийн үндэсний чуулган зохион байгуулагдаж, БШУГ-ын дарга, мэргэжилтэн, нийгмийн ажилтны төлөөлөл оролцлоо.
 13. “Хүүхэд өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдож буй эрүүл мэндийн асуудлын урьдчилан сэргийлэлт, үүсэж болох эрсдэлт хүчин зүйлийг бууруулах” агуулга, арга зүйг түгээх зорилгоор сургуулийн эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2022 танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдан 15 ЕБС, 2 МСҮТ, 1 политехникийн нийт 17 эмч хамрагдлаа.
 14. “Монгол бахархлын өдөр”-ийн хүрээнд төрт ёсны үнэт өв, үндэсний уламжлал, Эзэн Богд Чингис хааны суу алдар, аугаа их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, алдаршуулан мөнхжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 1 сарын аян зохион байгуулан, нийт 38 цэцэрлэг, 30 ЕБС, мэргэжлийн сургалтын 4 байгууллагын 1200 гаруй багш, 20000 гаруй суралцагчид хамрагдлаа.
Мөн ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийн сурагчдад зориулсан “Чингис хаан болон Монгол бахархал” сэдэвт ээлжит хичээлийг зохион байгууллаа.
 15. Боловсролын ерөнхий газар, Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын хэлтсээс зохион байгуулж буй “Насан туршийн суралцахуйн үзэл баримтлал, бодлого чиглэл боловсруулах арга зүй” Төвийн бүсийн зөвлөгөөнийг Зуунмод хотод 2 өдөр зохион байгуулагдан, 9 аймгийн Насан туршийн боловсролын төвийн 40 багш, захирлууд оролцлоо.

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Соёл урлагийн газар:

1. Монгол Улсын Соёлын яамнаас жил бүрийн 11 дүгээр сарыг “Соёлын бүтээлч сар” болгон зарладаг энэ удаагийн үйл ажиллагаа нь үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, соёлын үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалаар дамжуулан орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байна.
“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд аймгийн 30 соёл, урлагийн байгууллага “Соёлын өвийн ”долоо хоногоор нээлтээ хийж, 4 долоо хоногийн турш, батлагдсан тусгай төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгууллаа.
 - Нээлтийн арга хэмжээний хүрээнд “Хуур-өв эх эрдэнэ” морин хуурын домог танин мэдэхүйн сургалт, Зэвсэгт хүчний Хуурай Замын цэргийн командлалын 016 дугаар нэгтгэл ангитай хамтран “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” сэдвийн хүрээнд цэргийн албан хаагч нарт “Зохиолч уншигчийн уулзалт” зохион байгуулагдсан.
 - “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “Соёл ба уламжлал” сэдвээр СУИС-тай хамтран Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнд болон Зуунмод сумын иргэдэд уулзалт лекц, “Керамик”-ийн уран бүтээлчдын “Ваар-Урлал” бүтээлийн үзэсгэлэн, “Хүний эрхийн хамгаалал, соёлын гүйцэтгэх үүрэг хэлэлцүүлэг” цахим хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг 7 хоногоор төлөвлөн, зохион байгууллаа.
2. Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Төрийн архивын тасагтай хамтран Монгол бичгийн цахим бичвэрийн сургалт зохион байгуулж нийт 203 албан хаагч хамрагдлаа.
3. Эрдэнэ сумын Соёлын төвийн барилгад аймаг, орон нутгийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдэж, ашиглалтад орлоо.

Монгол Туургатан театр:

- Соёлын бүтээлч сарын “Бүх нийтийн соёлын боловсрол” 7 хоногийн хүрээнд “Бий биелгээ сурцгаая” сэдэвт танин мэдэхүйн хөдөлгөөнт сургалтыг ЕБС-ын 850 гаруй сурагчид, 6 төрийн байгууллагын албан хаагч нарт зохион байгууллаа.
- “Шившлэгтэй зургийн нууц” хүүхдийн жүжиг, “Сарьсан багваахайн домог” хүүхэлдэйн жүжгээрээ нийт Эрдэнэсант, Лүн зэрэг нийт 6 сумын ЕБС-ын 1900, цэцэрлэгийн 590 нийт 2490 хүүхдэд үйлчиллээ.
- Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага үүсч хөгжсөний 40 жилийн ойн баярын хүрээнд “Шившлэгтэй зургийн нууц” хүүхдийн жүжигт 160 хүүхэд, “Шар гэгээ” драмын жүжиг, “Учиртай гурван толгой” дуурийг тавьж, нийт 222 иргэн хамрууллаа.

Аймгийн Нийтийн номын сан:

1. Солонгос улсын Пёнток хотын номын сангийн урилгаар Төв аймгийн Нийтийн номын сангийн захирал, 2 номын санч 5 хоног Пёнток хотын Бижон, Сегю, Бедари номын сангуудын үйл ажиллагаатай танилцан, сургалтад хамрагдлаа.
2. “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын хүрээнд
-Хүүхэд залуучуудад Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах зорилгоор “Монгол бичиг, ёс заншил, бийрэн бичлэг”-ийн үзэсгэлэнг гаргаж 15ш бийрэн бичлэг, 115ш номоор 8 бүлгийн 269 хүүхэд, 57 насанд хүрэгчид нийт 326 хүнд үйлчилсэн.
-Нийтийн номын сангаас Соёлын бүтээлч сарын хүрээнд “Монгол бахархал”-ын тэмцээнийг нийт 6 багийн иргэдийн дунд зохион байгууллаа.
3. Д.Нацагдоржийн мэндэлсний 116 жилийн ойн баярын хүрээнд Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын номын үзэсгэлэн, “Яруу эгшиглэн-2022” богино өгүүллэгийн уралдаан зохион байгууллаа. Д.Нацагдоржийн амьдрал уран бүтээлээр контент нэвтрүүлэг хийсэн.

Аймгийн Музей:

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийн баг бүрэлдэхүүн маршрут үргэлжилж Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Сүмбэр, Жаргалан гэсэн 6 дурсгал тоологдож нийт тооллогын хувьд нэгдсэн цахим програмын бүртгэлд 88,6 хувийн гүйцэтгэлтэй байна.
2. Аймгийн Музейгээс “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “Төв телевизтэй хамтран “Манзуширын хийдийн бурхдын хөрөг” танин мэдэхүйн нэвтрүүлэг контент бүтээж, музейн пэйж хуудсаар иргэдэд хүргэн ажиллаа.
3. Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн Төрийн архивын тасагтай хамтран “Баримт түүх өгүүлэх нь” сэдэвт баримтат өвийн үзэсгэлэн гаргасан.
4. Соёлын биет бусын өвийн цахим үзлэг тооллогыг нийт 27 сумын хэмжээнд зохион байгуулж 252 өвлөн уламжлагч хамрагдаад байна.
5. Аймгийн музейгээс “Монгол бахархал” сэдвийн хүрээнд “Төрийн далбааны бэлгэдэл”-ийн тухай танин мэдэхүйн сургалтыг угсаатны танхимд зохион байгуулж “Хүмүүн цогцолбор” дунд сургуулийн 7е ангийн 40 сурагч хамрагдлаа

Сумдын Соёлын төв:

1. Сумдын Соёлын төвүүд “Соёлын бүтээлч сарын аян”-ы хүрээнд нэгдсэн төлөвлөгөөний дагуу олон арга хэмжээг төлөвлөн зохион байгууллаа. Үүнд: Баяндэлгэр сумын Соёлын төв ЕБС-ийн 1-9 ангийн сурагчдын дунд “Үлгэрээр хүмүүжье” соён гэгээрүүлэх ажлыг 2 долоо хоногийг хугацаатай зохион байгууллаа. зарласан. Жаргалант сумын Соёлын төв “Аз жаргалтай гэр бүл” арга хэмжээний хүрээнд сумын ИТХ-тай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулсан гм.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн боловсрол олгох, үетэнгийн дээрлэхэлтээс сэргийлэх, сургуулийн орчинд хүүхдийн гэмт хэрэг, зөрчил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ” аймгийн Аргалант, Баянцогт сумын ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгуулж, 7-12-р ангийн 329 сурагч, 55 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан, 15 хүүхдэд сэтгэл зүйн үйчилгээ үзүүлээ.

2. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх бүжгийн дугуйлангийн Wish wigs хамтлагийн хүүхдүүд тайлан тоглолт зохион байгууллаа.

3. Баян, Жаргалант сумдад насанд хүрээгүй хохирогчдын гэр бүлтэй нь уулзаж, нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Helpchildrenlife” системээр 108 дугаарын утсанд ирсэн нийт 189 дуудлага мэдээлэлд хариу өгч, хяналтандаа авч ажиллаж байгаа болно.

5. “Хүүхдийн мөнгө” зогсоох, сэргээх тухай 5 хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн.

ГЭР БҮЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран салбар зөвлөлийн болон сумдын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах бүсчилсэн сургалт Баяндэлгэр суманд зохион байгууллаа.

2. Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар ГБХЗХГ-ыг шинжээчээр томилсон. Шинжээчийн багийн гишүүд 2 нэхэмжлэгчийг байлцуулан нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллалаа.

3. Долоо хоног бүрийн Баасан гарагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” мэдээллээр “Дүрсгүй хүүхдээрээ бахархах 7 шалтгаан”, “Гэр бүлдээ чанартай цаг гаргая” 3 төрөл, “Аз жаргалын даавруудаа нэмэгдүүлэх аргууд” зэрэг 3 сэдвээр 5 төрлийн постер мэдээлэл бэлтгэн, байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1. Жендэрийн эрх тэгш байдлын талаарх залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх “Тэгш боломжийн төлөө-Залуучуудын манлайлал” сургалтыг Аргалант, Баянцогт, Борнуур суманд зохион байгуулан, 27 албан хаагч, 191 сурагчдыг хамрууллаа.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны санаачлагаар ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвөөс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын чуулганыг амжилттай зохион байгуулж зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд болон тэдний асран хамгаалагч нар 62 хүн оролцлоо.

3. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан А/157, А/233 тоот тушаалын “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд суллагдаж байгаа хоригдлуудад сургалт зохион байгууллаа.

4. Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-өөс Уран дэнт шүдний эмнэлэгтэй хамтран албан хаагчдын дунд амны хөндийн эрүүл мэндийн талаарх сургалтыг зохион байгуулж, алба хаагчдад үзлэг, оношилгоог үнэ төлбөргүй хийж цаашид амны хөндийн эрүүл мэндийн хямдралтай үйлчилгээнд хамруулан ажилласан.

5. Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 101 жилийн ойг тохиолдуулан “Эх оронч залуу” сургалт нөлөөллийн үйл ажиллагаа цахимаар болон танхимаар амжилттай зохион байгууллаа.

6. Монгол бахархалын өдрийг тохиолдуулан МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээнд 16 нас хүрч иргэний үнэмлэх авч байгаа өсвөр үе залуучуудын төлөөлөл 16 хүүхдийг оролцууллаа.

7. Залуучуудын хөгжлийн төвийн пэйж хуудсанд 11 сард 43 постер мэдээлэл байршуулж, 6242 хандалт авсан байна. Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан Гэрэлт ирээдүй сэтгэл судлалын хүрээлэнгийн захирал, сэтгэл судлаач нар өсвөр үеийн охид, хөвгүүд, залуучуудтай уулзалтын постер мэдээлэл хамгийн их буюу 1078 хандалтыг авсан байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

1. ЭМДЕГ-тай гэрээт Төв аймгийн 77 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 2,4 тэр бум төгрөгийн 35532 гүйцэтгэлд хяналт хийж, 4283 гүйцэтгэлийн 600 сая төгрөгний зөрчил илрүүлсэн.

2. Төр хариуцах иргэний ногдуулалтыг цахим болон ажлын байран дээр нийт 11 иргэнд орууллаа.

3. Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын “Хяналт шалгалт хийх тухай” А/154 тоот тушаалын дагуу 10 эрүүл мэндийн байгууллагын нийт 70 оношийн хамааралтай бүлэгт ажлын байран дээр үнэлгээ хийж, шалган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 559 даатгуулагчид 944,5 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 932 даатгуулагчид 123,2 сая, ажилгүйдлийн тэтгэмж 251 даатгуулагчид

575,5 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

НДЕГазрын албан бичиг, Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй гэрээ бүхий 22 эрүүл мэндийн байгууллагын 2020, 2021 оны санхүүгийн баримт, цалингийн баримтад үндэслэн нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж ажиллаа.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа 34 цаг хуралдаж, нийт 229 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 29 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 192 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 18 иргэнийг цуцалсан байна.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

2022 оны 11-р сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1915 иргэнд 5630,5 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1258 иргэнд 1133,2 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 1077 иргэнд 855,8 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 43 иргэнд 51.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9702 иргэнд 1249,3 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 4710 ахмад настанд 485,7 сая, Насны хишиг 5760 ахмадад 916,6 сая төгрөг, 1068 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 157,8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 5438 иргэнд 544,7 сая төгрөг, жирэмсэн 1571 эхэд 256,2 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6683 иргэнд 2103,3 сая төгрөгийн тэтгэмж, өрх толгойлсон 324 иргэнд 381,2 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 26 иргэнд 52 сая төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5 сая төгрөг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр:

“Төгсөлтийн аргачлал” төсөл хөтөлбөрт 2023-2024 онд шинээр сонгон ажиллах 457 өрхийг сонгох шалгуур, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, эрчимжүүлэх ажлын чиглэлийг сумдын Засаг дарга, сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар 13 хүүхдийг асуудлыг хэлэлцүүлж, байнгын асаргааг сунгасан. Мөн шинээр 6 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож, хүүхдийг цэцэрлэг сургуульд хамруулах шийдвэр гаргалаа. Мөн Жайка Олон Улсын Байгууллагаас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлын явцтай танилцаж, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийн кейс тайлангийн хэлэлцүүлэг хийж, хүүхэд тус бүр дээр харилцах дэвтэр хөтлөх заавар танилцуулга хийсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хамт олны бүлгийн төсөл хэрэгжүүлж, ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдүүлэх төслийн сонгон шалгаруулалтад 7 сумын 4 бүлгийн төслийг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар оруулан хэлэлцүүлж, дэмжлэг авсан төслийн бүлгийн ахлагч, гишүүдтэй гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгөний талаар:

0-18 хүртэлх насны 90 хүүхдийг и-халамж системээр бүртгэж, нэр данс зөрүүтэй, хүүхдийн мөнгө бэлнээр авах хүсэлтээ гаргаагүй 7 сумын 39 хүүхдийн мэдээллийг хүүхдийн эцэг эх асран хамгаалагчид утсаар мэдээлж мэдээллийг ихаламж програмд засварлан нийт 34210 хүүхдэд 37411.8 сая төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж олгосон.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 975 өрхийн 5438 иргэнд 504,2 сая төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилсан сэргийлж ажилласан.

Зуунмод сумын хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг 228 өрх, Аргалант сумын 4 өрх, Заамар сумын 52 өрхөөр зочилж нөхцөл байдлын үнэлгээ хийж, журмын хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 11 сарын байдлаар Шинээр бий болсон 176 /нийт 1035/-н шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан.

Сул чөлөөтэй ажлын байранд ажил хайгчаар бүртгүүлсэн 107 иргэнийг зуучилж /нийт 629/ иргэн ажилд зуучлагдлаа.

Түр ажлын байранд ажилласан 2378 /нийт 10908/ иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Тайлант хугацаанд 24 иргэний 38057,1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 431 иргэний 441214,54 мянган төгрөг төлөгдсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт Миндиотайди, Монволфарм ХХКомпани 6 иргэний 11323,2 мянган төгрөг төлөгдөж, нийт 31 иргэний 125939,38 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн байна.

ХЭДСанд 1749950,0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн бөгөөд тайлант сард 1090453,4 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд:

Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд 3 сумын 30 иргэнд 12,0 сая төгрөг, Нийтийг хамарсан ажил төсөл хөтөлбөрийн хүрээнд 1 сумын 10 иргэнд 3,2 сая төгрөг, Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Борлуулалтын дэмжлэгт 600,0 мянган төгрөг, Хүүхэд хамгаалал төсөлд Зуунмод сумын 2 иргэнд 560,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Сонор едүкейшн сургалтын төвтэй хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Жаргалант сумын сургуулийн 9-р ангийн 115 суралцагчдад бүлгээр зохион байгуулсан.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг Борнуур, Жаргалант сумын Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны 60 иргэнд зохион байгууллаа.

Сэргэлэн сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 1 иргэнийг Их номч мэлмий ХХК-ийн дэргэдэх Бодит үнэлэмж сургалтын төвд оёдол, эсгүүрийн мэргэжлээр, Архуст сумын Оролцоо төсөлд хамрагдсан 1 иргэнийг Эрдэнэ сумын МСҮТ-д тогоочийн мэргэжил олгох сургалтад хамруулж байна

Байгууллагын үйлчилгээнд нэвтрүүлсэн ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах 3-р шатны баталгаажуулалтад амжилттай орж, гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалах эрх авсан.

Хэнтий аймгийн Өндөрхаан хотод зохион байгуулагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилчдын дунд зохион байгуулагдсан 5-н төрөлт тэмцээнд багийн дүнгээр тэргүүн байр, Улаанбаатар хотод 2022 оны 11 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан салбарын Улсын Аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн.

Холт Интернэйшнл ОУБ-ын санхүүжилтээр хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн амьжиргааг дэмжих” төсөл хөтөлбөрт хамрагддаг 50 хүүхдийн жилийн эцсийн явцын тайлан судалгааг маягтын дагуу гаргаж, хүүхдийн өсөлт хөгжлийн талаарх мэдээллийг шинэчлэн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд хүргүүллээ. Зуунмод сумын 40 өрхийн 50 хүүхдэд Холт олон улсын байгууллагаас хүүхэд тус бүрд сард 15\$-ийн тусламж үзүүлж байна.

Холт Олон Улсын байгууллагаас “Хүүхдийн амьжиргааг дэмжих” төсөл хөтөлбөрийн зохицуулагч Зуунмод суманд ажиллаж, хөтөлбөрт хамрагддаг хүүхдүүдтэй уулзаж, нөхцөл байдлын үнэлгээ хийн, ивээн тэтгэгч нарт хүргүүлэх талархлын захидал, зурагт мэндчилгээ бүхий явцын тайлан хүргүүлэн ажилласан.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Спорт форум-2022 арга хэмжээг зохион байгуулан, 18 холбоо, клубын 31 хүн хамрагдаж спортын төрлүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь чиглэлээр санал солилцлоо.

Аймгийн хэмжээнд нийт 5 удаагийн спортын тэмцээн уралдаан зохион байгуулан, 27 замын 98 багийн, 1166 тамирчид оролцлоо. Үүнд: Нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 30-н жил, улс тунхагласны 98 жилийн ойн хүрээнд УИХ-ын гишүүн Н.Энхболдын нэрэмжит “Атарчин-2022” спортын наадам, аймгийн Цагдаагийн газрын хэлтэс албадын дундах сагсан бөмбөгийн тэмцээн, аймгийн Засаг даргын нэрэмжит бие бялдар хөгжил чийрэгжилтийн уралдаант үзлэг, “Анандын зам” ХХК-ний нэрэмжит засмал замын дугуйн улирлын хаалтын тэмцээн, “Мөрөөдлийн гоол” зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Арабын нэгдсэн Эмират улсад зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах Жюу Жицү тэмцээнд Төв аймгаас 5 тамирчин 1 дасгалжуулагч оролцож ХЦС-ийн сурагч жү-до

бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчин Б.Мишээл, Чандмань оргил дэвжээний тамирчин Д.Номин 63 кг-ын жинд алт, Зуунмод политехникийн коллежийн оюутан Ч.Урангоо 57 кг-ын жинд хүрэл медаль хүртлээ.

Олимпын таеквондогийн бага насны улсын аварга шалгаруулах тэмцээн Өвөрхангай аймагт зохион байгуулагдан, манай баг тамирчид 3 алт, 2 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 2-р байрыг эзэллээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Дайчилгаа удирдах томолгоот бүлгүүдийн Цугларах байрын сургалтыг Ерөнхий боловсролын 4-р сургууль, Шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүний сургалтыг авто тээврийн төвтэй хамтран зохион байгуулж дадлага, сургуулалтыг хийж ажиллалаа.

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт, маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд 2022 онд хугацаат цэргийн албанд шинээр татагдан ирсэн дайчдын Цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаа Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, дэлхий дахинаа Бүгд Найрамдах Улсаа тунхагласан зарласан 98 жилийн ойн түүхт өдөр амжилттай явагдлаа. Ёслолын арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга, бригадын генерал С.Ганбямба хүрэлцэн ирж оролцож, шинэ дайчдад албаа нэр төртэй хаахыг захисон нь үйл ажиллагааны онцлог нь байлаа. ЗХЖШ-ын даргыг дагалдаж Зэвсэгт хүчний Кибер, аюулгүй байдлын цэргийн командлагч, бригадын генерал Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Д.Дугаррагчаа, Төв аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр болон нэгтгэлээс тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад дайчдын төлөөлөл, шинэ дайчдын ар гэрийнхэн тангараг өргөх ёслолын ажиллагаанд оролцлоо. Тангараг өргөх арга хэмжээний үеэр аймгийн Засаг даргын цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад амжилттай суралцсан байлдагчдад Засаг даргын гарын бэлэг гардууллаа.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР